

“МОРСТЭП - Нүүдэл, шилжилт хөдөлгөөний эрсдэлд: Монгол орны тал хээрийн экосистемийн тогтвортой байдлыг хадгалах нь” төсөл

Дугаар №3

www.morestep.org

2022 оны 11-р сар

Редакторын үг

Бид та бүхэнд МОРСТЭП төслийн гурав дахь мэдээний тоймыг хүргэж буйг хүлээн авна уу! МОРСТЭП төсөл нь ХБНГУ-ын Боловсрол, Судалгааны Яамны санхүүгийн дэмжлэгтэйгээр 2 орны хамтарсан салбар дундын төсөл юм.

Энэ удаа МОРСТЭП төслийн хүрээнд хэвлэгдсэн “Малчдын нүүдлийн хувийн зардал-өгөөжийн шинжилгээ” сэдэвт эрдэм шинжилгээний өгүүлийн үр дүнг та бүхэнд хүргэж байна.

Таалан соёрхоно уу!

МОРСТЭП төслийн хамт олноос

Малчдын нүүдэл

Нүүдэл буюу “нүүдэлчин амьдралын хэв маяг” нь байгаль орчны доройтлоос сэргийлэх стратеги юм. Бидний тодорхойлсноор “Малчдын нүүдэл гэдэг нь нүүдлийн мал аж ахуйд суурилсан амьжиргаагаа тэтгэхийн тулд өвс, ус сайтай бэлчээр нутгийг олох, бэлчээрийг сэлгэн ашиглах зорилгоор хийж буй өрхийн нүүдлийг хэлэх ба энэ нь нэг төрлийн менежментийн стратеги юм”. Гэтэл 1990-ээд оноос хойш эдийн засгийн өсөлт, малын тоо толгой ихээр нэмэгсэнтэй холбоотой малчдын нүүдэл хумигдсан. Эндээс үүдэн дараах асуулт урган гарна. Үүнд:

“Малчид нүүдэл хийх нь тэдэнд хэр зэрэг эдийн засгийн өгөөжтэй вэ?”

Бид 2020 онд Төв, Хэнтий, Сүхбаатар, Дорнод аймгийн 288 малчин өрхөөс асуулга авах замаар нүүдлийн мэдээллийг цуглуулсан.



Зардал-өгөөжийн шинжилгээ хийхийн тулд малын амьдын жин, сүүний гарцыг нүүдэлтэй холбон судлах зорилгоор 2020 онд нийт 69 өрхийн 942 хонь, ямаа, үхэр жинлэж, 352 ямаа, үнээ саасан.

Малчдын нүүдлийн зардал

Судалгаанд хамрагдсан 288 өрх жилд дунджаар 358 мянган төгрөгийг нүүдэлд зарцуулсан бөгөөд нэг хонин толгой малд ногдох зардал нь 753 төг байжээ. Нүүдлийн зардлын 63.6%-ийг хөдөлмөр, 30.8%-ийг түлш, 5.5%-ийг машины түрээсийн зардал тус тус эзэлж байна.

Малчдын нүүдлийн өгөөж

Малчид нүүдэл хийснээр дараах гурван төрлийн өгөөжийг хүртэх боломжтой юм. Үүнд: 1) Малын амьдын жингийн өсөлт, 2) Малын сүүний гарцын өсөлт, 3) Хадлангийн зардал буурах зэргийг авч үзсэн. Судалгаанд бид нүүдлийн давтамж (Жилд хийсэн нийт нүүдлийн тоо) болон нүүдлийн зай (Жилд нүүсэн нийт зай) гэсэн хоёр төрлийн хэмжигдэхүүнийг ашиглан тус бүр загварчилсан.

Нүүдлийн давтамжаар тооцход нэг малчин өрхийн нэг хонин толгойд ногдох нүүдлийн нийт өгөөж 5,088 төгрөг байв. Үүний 76.7%-ийг малын амьдын жингийн өсөлт, 23%-ийг нь хадлангийн зардал хэмнэлт, 0.3%-ийг сүүний гарцын өсөлтийн өгөөж тус тус эзэлж байжээ. Нөгөө талаас нүүдлийн зайгаар тооцож үзэхэд нэг хонин толгойд ногдох нүүдлийн нийт өгөөж 3,770 төгрөг гэж тооцоологдсон. Зайгаар тооцсон загварт нүүдлийн сүүний гарцын болон хадлан хэмнэсний өгөөж илрээгүй учир нийт өгөөж нь малын амьдын жингийн өсөлтөөр тайлбарлагдаж байна.


Нүүдлийн зай эсвэл давтамж

Нүүдлийн давтамжаар тооцсон өгөөжийг графикт харахад нүүх тоо тодорхой хэмжээнд хүртэл нийт өгөөж өсч оргилдоо хүрсний дараа буурах зүй тогтолтой байна. Тухайлбал, жилдээ 4 удаа нүүсэн өрхүүдийн нэг хонин толгойд ногдох өгөөж дунджаар хамгийн өндөр (7,100 төгрөг) байсан бол, 4-өөс олон эсвэл цөөн нүүсэн өрхийн нүүдлийн өгөөж буурах хандлагатай байна (Зураг 1).



Зураг 1. Нэг хонин толгойд ногдох нийт зардал, өгөөж, нүүдлийн давтамжаар

Нүүдлийн зайгаар тооцсон нийт өгөөж нь график дээр огцом өсөлттэй харагдаж байна (Зураг 2). Эндээс үзвэл хол нүүх тусам өндөр өгөөжтэй болохыг харуулж байна.



Зураг 2. Нэг хонин толгойд ногдох нийт зардал, өгөөж, нүүдлийн зайгаар

Дүгнэлт

Нүүдэл нь малчдад чухал ач холбогдолтой хэдий ч хэт олон нүүх нь үр ашиггүй юм. Судалгааны үр дүнгээс үзэхэд малчид жилдээ ойролцоогоор 4 удаа нүүх нь эдийн засгийн хувьд хамгийн өндөр өгөөжтэй байна. Нөгөө талаас, хол зайд нүүх нь ойрхон нүүхээс илүү үр өгөөжтэй ажээ.

Эх сурвалж

Ганзориг, Г., Сугар, Д. (2021). Малчдын нүүдлийн хувийн зардал-өгөөжийн шинжилгээ. Хөдөө аж ахуйн шинжлэх ухаан сэтгүүл, 34(3), 65–79. <https://doi.org/10.5564/mjas.v34i3.1921>,